



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/34

Хөхбүрд

Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал
засвар хийх тендерийн үнэлгээний
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын тээвэр, шатахууны тендерт оролцогчдыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Үлэмжсонин (Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч)

Гишүүд: Д.Эрдэнэбулган (Санхүүгийн албаны дарга)

Д.Отгонцэцэг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Г.Ууганжаргал (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Ж.Ганцэцэг (Татварын улсын байцаагч)

2.Тендерийн үнэлгээний хороонд ажиллах гишүүд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасан мэдээллийг гаргаж, тендерт сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа авах үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллахыг үнэлгээний хорооны гишүүдэд даалгасугай.

3.Тендерийн материалыг баталгаажуулан стандартын дагуу архивын нэгж үүсгэн Засаг даргын Тамгын газрын архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга (Ж.Ганцэцэг)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Ж.ХАТАНБААТАР

642301033